

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/22/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.5.2 Авлага .....	11
3.5.4 Бараа материал.....	11
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	12
3.5.7 Өр төлбөр.....	12
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/232  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Баян сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 88,7 хувиар, 2023 оны сумын хөгжлийн төлөвлөгөөг 80,3 хувиар хэрэгжүүлсэн дүнтэй байна.

### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант онд ОНХС болон шилжих үлдэгдлээс ЕБС-ийн хүүхдийн сурах орчин сайжруулах, стандартын шаардлага хангасан спорт заалтай болох зорилгоор 358,351.5 мянган төгрөг, гудамжны гэрэлтүүлгийн ажилд 150,368.7 мянган төгрөг, 2024 онд хийгдэх ажлын зураг төсөв хийлгэх зардалд 79,954.6 мянган төгрөгийг төлөвлөж 10 ортой ЭМТөв, мооргийн барилгын ажлын зураг төсвийн ажилд 36,300.0 мянган төгрөг нийт 545,020.2 мянган төгрөгөөр нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн байна.

G/Arkhib/Alban bichig 2024/ A4

010000500

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,521,976.1	2,515,692.8
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	1,163,450.1	1,328,455.8
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	256,592.0	1,092,042.9
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	101,934.0	95,194.1
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		2,553,345.2	2,871,514.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	2,553,345.2	2,871,514.2
39200	Биет хөрөнгө		1,851,032.7	2,170,813.6
39300	Биет бус хөрөнгө	13	702,312.5	700,700.5
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		4,075,321.3	5,387,207.0
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		12,190.0	16,143.5
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	12,190.0	16,143.5
41300	Өглөг	17а, 17б	12,190.0	16,143.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		4,063,131.3	5,371,063.5
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		4,063,131.3	5,371,063.5
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,268,467.9	1,268,467.9
51200	Хуримтлагдсан үр дүн		1,833,071.9	3,141,004.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		961,591.4	961,591.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		4,075,321.3	5,387,207.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		3,761,486.6	3,025,741.6
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		1,124,992.1	826,674.4
110	Орлогын албан татвар		283,890.7	454,612.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		299,782.5	471,612.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-15,891.8	-17,000.0
113	Хөрөнгийн албан татвар		33,525.3	48,247.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		807,576.0	323,814.5
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	233,316.1	1,673,443.3
120	Нийтлэг татварын бус орлого		233,316.1	1,669,813.3
122	Тусламжийн орлого		0.0	3,630.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		2,403,178.4	525,623.9
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	3,792,659.8	1,717,339.4
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		2,973,135.2	1,496,548.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		887,708.2	1,236,892.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		266,781.4	483,434.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		32,675.5	59,472.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		291,306.5	61,551.1
2104	Хангамж, бараа материалын зардал		30,402.4	40,577.7
2105	Нормативт зардал		25,364.6	26,123.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,638.2	2,924.1
2107	Томилолт, зочны зардал		2,452.0	4,012.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		33,712.9	318,102.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		200,374.6	240,694.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,085,427.1	259,656.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		819,524.6	220,790.7
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		-31,173.2	1,308,402.2
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		2,858,942.8	470.0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		-2,890,116.0	1,307,932.2

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	3,677,798.1	2,739,529.4
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	1,124,992.1	826,674.4
110	Орлогын албан татвар	283,890.7	454,612.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	299,782.5	471,612.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,891.8	-17,000.0
113	Хөрөнгийн албан татвар	33,525.3	48,247.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	807,576.0	323,814.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,958.6	38,160.4
1181	Газрын төлбөр	569,094.6	173,444.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	223,522.8	112,209.1
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	149,627.7	1,387,231.0
120	Нийтлэг татварын бус орлого	149,627.7	1,383,601.0
122	Тусламжийн орлого	0.0	3,630.0
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,403,178.4	525,623.9
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,850,041.2	1,292,884.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,850,041.2	1,292,884.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	753,650.2	1,032,628.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,956.0	483,434.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,675.5	59,472.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,306.5	61,551.1
2104	Хангамж, бараа материалын зардал	27,235.5	34,854.6
2105	Нормативт зардал	33,404.2	17,845.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,129.8	2,163.0
2107	Томилолт, зочны зардал	2,452.0	4,012.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,152.6	318,595.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,338.0	50,699.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,096,391.0	260,256.3
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	827,756.9	1,446,644.8
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	1,325,648.1	1,161,169.1
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,325,648.1	1,161,169.1
2200	Дотоод эх үүсвэрээр	1,325,648.1	1,161,169.1
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-1,325,648.1	-1,161,169.1
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-55,972.4	-120,470.0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	55,972.4	120,470.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-553,863.5	165,005.7
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,717,313.6	1,163,450.1
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,163,450.1	1,328,455.8

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний	Нийт цэвэр хөрөнгө/өм
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,998,933.3	6,998,933.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,063,131.3	4,063,131.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,953,247.3	6,953,247.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-45,686.0	-45,686.0
9	Тайлант үеийн үр дүн	-2,890,116.0	-2,890,116.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,063,131.3	4,063,131.3
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,371,063.5	5,371,063.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,063,131.3	4,063,131.3
19	Тайлант үеийн үр дүн	1,307,932.2	1,307,932.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,196,869.0	2,233,279.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,160,467.7	975,240.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,142,676.6	957,461.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	480,472.8	446,148.1
210101	Үндсэн цалин	392,531.8	315,968.7
210102	Нэмэгдэл	81,414.7	77,476.4
210104	Урамшуулал	6,526.3	47,114.2
210105	Гэрээт ажлын хөлс	-	5,588.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,059.2	54,903.9
210201	Тэтгэврийн даатгал	40,840.2	38,296.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,804.8	4,505.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,843.8	3,600.0
210204	Ажилгүйдлийн даатгал	961.0	769.5
210205	Эрүүл мэндийн даатгал	9,609.4	7,732.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	394,240.5	370,778.4
210301	Гэрэл, цахилгаан	43,476.5	33,895.8
210302	Түлш, халаалт	349,065.0	334,789.8
210303	Цэвэр, бохир ус	1,699.0	2,092.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,863.3	34,854.6
210401	Бичиг хэрэг	2,379.6	3,989.9
210402	Тээвэр, шатахуун	15,743.7	16,331.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,240.0	1,525.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	12,500.0	12,494.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.0	513.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,450.0	7,312.1
210604	Урсгал засвар	7,450.0	7,312.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,595.6	4,012.0
210702	Дотоод албан томилолт	4,595.6	4,012.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	14,084.8	4,160.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	9,500.0	378.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,608.0	1,116.0
210803	Даатгалын үйлчилгээ	250.0	246.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486.8	486.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240.0	240.0
210807	Газрын төлбөр	2,000.0	1,691.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	146,910.4	35,291.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,110.4	32,491.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800.0	2,800.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,791.1	17,779.4
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,791.1	17,779.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,791.1	15,791.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0	1,988.3
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	2,875,270.9	1,137,569.1
220001	Барилга байгууламж	1,563,027.8	498,405.5
221001	Их засвар	417,437.5	378,737.5
222001	Тоног төхөөрөмж	98,054.5	74,982.0
223001	Бусад хөрөнгө	796,751.1	185,444.1
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	161,130.4	120,470.0
230001	Эргэж төлөгдөх зээл	161,130.4	120,470.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,196,869.0	1,999,424.6
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	358,351.5	349,380.6
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	358,351.5	349,380.6
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,014,031.7	1,580,433.8
320001	Орон нутгийн төсвөөс	3,014,031.7	1,580,433.8
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	824,485.8	65,980.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,130.4	65,980.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	663,355.4	-
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	3,630.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	-	3,630.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	61,170.3	225,381.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	61,170.3	205,781.4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	34,139.5	57,262.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	37,286.3
210101	Үндсэн цалин	-	10,755.9
210102	Нэмэгдэл	-	26,530.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	4,568.8
210201	Тэтгэврийн даатгал	-	3,328.7
210202	Тэтгэмжийн даатгал	-	372.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	298.3
210204	Ажилгүйдлийн даатгал	-	66.2
210205	Эрүүл мэндийн даатгал	-	502.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,055.7	-
210402	Тээвэр, шатахуун	1,055.7	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	296.3	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296.3	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,787.6	15,407.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,787.6	15,407.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,030.8	148,518.7
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	27,030.8	148,518.7
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	147,584.1
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	934.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	19,600.0
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	19,600.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	19,600.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	61,170.3	225,381.4
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	61,170.3	225,381.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,993.8	178,629.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,176.5	46,751.8

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Баян сум нь 2023 оныг “түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих жил” болгон зарлаж, хоршоог хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилго, зорилт тавин ажилласнаар кофе шоп, үхрийн аж ахуй, хоол үйлдвэрлэл шинээр буй болж үйлдвэрлэл үйлчилгээ хэвийн явагдаж байна.

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 8 бодлогын хүрээнд 39 зорилтын хүрээнд 147 арга хэмжээ төлөвлөж ажилласан ба хэрэгжилт 88,7 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Мөн 2023 оны сумын хөгжлийн төлөвлөгөө бодлогын хүрээнд 39 зорилтын 108 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 80,3 хувьтай хэрэгжсэн дүнтэй байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтыг завсрын аудитаар хянаж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг жилд 2 удаа хийгдсэн ба сумын Засаг даргаас ажлын хэсэг томилон эмийн эргэлтийн сангийн хагас болон жилийн эцсийн тооллогыг хийж ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,387,207.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,311,885.7 мянган төгрөгөөр буюу 32,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1163450.1	1328455.8	165005.7
АВЛАГА	256592.0	1092042.9	835450.9
БАРАА МАТЕРИАЛ	101934.0	95194.1	-6739.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2553345.2	2871514.1	318168.9
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4075321.3</b>	<b>5387207.0</b>	<b>1311885.7</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	12190.0	16143.5	3953.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	4063131.3	5371063.5	1307932.2
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4075321.3</b>	<b>5387207.0</b>	<b>1311885.7</b>

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,328,455.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 165,005.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь өмнөх оноос орон нутгийн ерөнхий орлогын данс 400,358.4 мянган төгрөгөөр өсөж, Орон нутгийн хөгжлийн сангийн болон хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 54,489.8-179,365.5 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 1,092,042.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 835,450.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оноос Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 385,680.6 мянган төгрөгөөр, Засаг даргын тамгын газрын авлага 363,790.7 мянган төгрөгөөр хоршоо хөгжүүлэх сангийн авлага 72,536.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 95,194.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,739.9 мянган төгрөгөөр буурсан нь эмийн эргэлтийн сангийн эм боох материалын үлдэгдэл 8,278.2 мянган төгрөгөөр багассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,871,514.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 318,168.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Засаг даргын тамгын газар, ИТХ, эмийн эргэлтийн сан зэрэг байгууллагууд нь үндсэн хөрөнгө бэлтгэсэнээс шалтгаалсан байна.

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 16,143.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,953.5 мянган төгрөгөөр өссөн нь мал хамгаалах санд тайлагнагддаг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд төвлөрсөн 2,500.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн болон ЗДТГ-т 1,453.5 мянган төгрөгийн өр шинээр үүссэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 5,371,063.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,307,932.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,328,455.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 165,005.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1163450.1</b>	<b>1328455.8</b>	<b>165005.7</b>
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1163450.1</b>	<b>1328455.8</b>	<b>165005.7</b>
<b>Төгрөг</b>	<b>1163450.1</b>	<b>1328455.8</b>	<b>165005.7</b>
Төрийн сангийн харилцах	1153466.0	1322469.1	169003.1
Арилжааны банк дахь харилцах	9984.1	5986.7	-3997.4

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 1,322,469.1 мянган төгрөгийн 69,1 хувь буюу 918,564.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 18,8 хувь буюу 249,357.3 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 7,3 хувь буюу 97,552.2 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 4,3 хувь буюу 56,995.1 мянган төгрөгийг мал хамгаалах сан ба байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн 5,986.7 мянган төгрөгийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,092,042.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 835,450.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>АВЛАГА</b>	<b>256592.0</b>	<b>1092042.9</b>	<b>835450.9</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	8716.0	21883.3	13167.3
<b>Бусад авлага</b>	<b>247876.0</b>	<b>1070159.6</b>	<b>822283.6</b>
Байгууллагаас авах авлага	149225.5	884173.6	734948.1
Хувь хүмүүсээс авах авлага	98650.5	185986.0	87335.5

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын жилийн эцсийн үлдэгдэл 1,092,042.9 мянган төгрөгийн 40,5 хувийг Засаг даргын тамгын газрын, 35,6 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 21,9 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн, 2,0 хувийг эмийн эргэлтийн сангийн авлага эзэлж байна. Нийт авлагын 76,1 хувийг эзэлж буй авлага нь хөрөнгө оруулалтын дутуу гүйцэтгэлээс үүссэн байна. Сумын ЗДТГ нь тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хийгдэж дуусаагүйгээс 438,245.7 мянган төгрөгийн ажлыг авлагаар бүртгэж тайлагнасан. Мөн өвс тэжээлийн фондод хивэг авахаар жилийн эцэст мөнгөө шилжүүлсэн боловч татаж авч амжаагүй 4,180.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн. Мөн оны эхний үлдэгдлээс 50,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зэргээс шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт

• Сумын ИТХ-аас хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 996,630.7 мянган төгрөгөөр 20 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас нийт 383,428.9 мянган төгрөгийн 5 жил олт хийгдээгүй, 388,245.7 мянган төгрөгийн 5 ажлыг дутуу гүйцэтгэсэн, нийт хөрөнгө оруулалтын ажлын 77,4 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 95,194.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,739.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>101934.0</b>	<b>95194.1</b>	<b>-6739.9</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>19297.1</b>	<b>10485.8</b>	<b>-8811.2</b>
Тусгай зориулалттай материал	2051.5	2051.5	0.0
Эм боох материал	17245.6	8434.4	-8811.2
<b>Хангамжийн материал</b>	<b>71567.0</b>	<b>71558.3</b>	<b>-8.7</b>
Бичиг хэргийн материал	2459.6	1973.2	-486.4
Аж ахуйн материал	52331.4	55177.6	2846.3
Сэлбэг хэрэгсэл	970.0	1904.0	934.0
Бусад хангамжийн материал	15806.0	12503.5	-3302.5
Мал амьтад	11070.0	13150.0	2080.0

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 95,194.1 мянган төгрөгийн 88,0 хувийг Засаг даргын тамгын газрын, 7,6 хувийг эмийн эргэлтийн сангийн, 4,4 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасны дагуу сумын Засаг даргын албан тушаалын LEXUS -470 автомашин бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

ИТХ-ын нарийн бичгийн даргын тушаалаар Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны хоол, хүнсний материалын үнэнд 3,231.4 мянган төгрөгийг зарцуулалт, гүйцэтгэлийн тайлангүйгээр зарцуулсанд зөрчлийг таслан зогсоох зөвлөмж хүргүүлсэн.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,871,514.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 318,168.9 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн 99,6 хувийг Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2553345.2</b>	<b>2871514.1</b>	<b>318168.9</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>1851032.7</b>	<b>2170813.6</b>	<b>319780.9</b>
Барилга, байгууламж, орон сууц	2793742.8	2793742.8	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-1668689.4	-1736863.1	-68173.7
Авто-тээврийн хэрэгсэл	230076.0	243864.6	13788.6
Хуримтлагдсан элэгдэл	-190296.0	-165803.8	24492.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	119833.7	177847.8	58014.1
Хуримтлагдсан элэгдэл	-56506.5	-77867.8	-21361.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	44779.7	49969.0	5189.3
Хуримтлагдсан элэгдэл	-25745.5	-33884.3	-8138.8
Бусад үндсэн хөрөнгө	434858.5	819034.8	384176.3
Хуримтлагдсан элэгдэл	-128559.9	-196765.9	-68206.0
Дуусаагүй барилга, байгууламж	297539.3	297539.3	0.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>702312.5</b>	<b>700700.5</b>	<b>-1612.0</b>
Програм хангамж	8092.5	8092.5	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-5238.0	-6850.0	-1612.0
Бусад биет бус хөрөнгө	699458.0	699458.0	0.0

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 318,168.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЗДТГ орон нутгийн шилжих үлдэгдлээс батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаар хийгдсэн 239,575.7 мянган төгрөгийг, ОНХС болон бусад эх үүсвэрээс бэлтгэсэн 209,483.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар шинэ хөдөө төслийн хүрээнд ХХААХҮГ-аас 2024 онд ирүүлсэн 57,088.6 мянган төгрөгийн 90 морины хүчин чадалтай трактор, 31,456.0 мянган төгрөгийн үрлүүрийг, нийт 88,544.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад бүртгэж тайлагнасан.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 16,143.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,953.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12190.0</b>	<b>16143.5</b>	<b>3953.5</b>
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	1453.5	1453.5
<b>Бусад өглөг</b>	<b>12190.0</b>	<b>14690.0</b>	<b>2500.0</b>
Байгууллагад төлөх өглөг	12190.0	14690.0	2500.0

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 20223 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 3,953.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ болон байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд өглөгийг шинээр бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,371,063.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,307,932.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4063131.3</b>	<b>5371063.5</b>	<b>1307932.2</b>
Засгийн газрын оруулсан капитал/ Орон нутгийн	1268467.9	1268467.9	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1833071.9</b>	<b>3141004.1</b>	<b>1307932.2</b>
Өмнөх үеийн үр дүн	4723187.9	1833071.9	-2890116.0
Тайлант үеийн үр дүн	-2890116.0	1307932.2	4198048.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	961591.5	961591.5	0.0

/ мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Баян сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,307,932.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баян сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 789,326.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн жилд зарцуулах зардлыг ЗДТГ 436,500.0 мянган төгрөг, ИТХ 211,500.0 мянган төгрөг, төсвийн байгууллагуудын тогтмол зардлыг 336,400.0 мянган төгрөг, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 984,400.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн орлогыг 458,932.3 мянган төгрөгөөр өсгөж 1,248,258.7 мянган төгрөгөөр баталсан байна. Хагас жилийн төсвийн тодотгоор төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,980,608.5 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Баян сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “сумын 2023 оны төсөв батлах тухай” 01 дүгээр тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,248,258.7 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,744,298.1 мянган төгрөгөөр баталсан.

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Сумын 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 732,349.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,980,608.5 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 3,163,445.8 мянган төгрөгөөр, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 433,032.1 мянган төгрөгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийг 358,351.5 мянган төгрөгөөр, тус сангийн шилжих үлдэгдэл 230,323.3 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 161,130.4 мянган төгрөгөөр, нийт 3,163,445.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,980,608.5 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл

433,032.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрийг 358,351.5 мянган төгрөг, тус сангийн шилжих үлдэгдэл 230,323.3 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр санхүүжүүлэх 38,947.4 мянган төгрөг, аймагт татан төвлөрүүлэлт 241,542.3 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 161,130.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын ба татварын бус орлого 2,361,489.6 мянган төгрөг төвлөрч, орон нутгийн байгууллагуудад 2,182,336.6 мянган төгрөгийг санхүүжилт олгож, тайлант хугацаанд зарцуулаагүй 562,955.5 мянган төгрөг, илүү олгосон санхүүжилт 38,947.4 мянган төгрөг, нийт 601,902.9 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна. Мөн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 46,751.8 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 178,629.5 мянган төгрөг, ОНХС-ийн орлогоор 349,380.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,233,279.9 мянган төгрөг буюу 70,6 хувь байна. Энэ нь цалин нэмэгдэл хөлс 34,324.7 мянган төгрөг, НДШ-ээс 5,155.3 мянган төгрөг, тогтмол зардал 23,462.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 8670.8 мянган төгрөг, Эд хогшил урсгал засварын зардал 137,9 мянган төгрөг, томилолтын зардал 583,6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 9,924.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 111,618.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгээс 11.7 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 377,728.5 мянган төгрөг тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

№	Хөтөлбөр арга хэмжээ	төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			биелэлт	зөрүү	биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үндсэн үйл ажиллагаа	93,973.8	89,674.4	4,299.4	95.4
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,000.0	998.0	2.0	99.8
3	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын багийн ИНХ-н даргын урамшуулал	7,342.1	7,342.1	-	100
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	5,000.0	4,998.3	1.7	99.9
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын үндсэн үйл ажиллагаа	428,960.9	382,849.1	46,111.8	89.2
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	79,405.0	74,863.8	4,541.2	94.3
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын баг хорооны үйл ажиллагааны зардал	61,012.4	60,869.0	143.4	99.8
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	16,791.1	16,781.4	9.7	99.9
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын бусад	972,683.2	594,954.7	377,728.5	61.2
10	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,993.6	6.4	99.9
11	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	-	100
12	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	108,110.4	-	108,110.4	0
13	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх	12,500.0	12,494.6	5.4	99.9
14	Ерөнхий боловсрол –тогтмол зардал	193,234.5	181,773.3	11,461.2	94.1
15	Сургуулийн өмнөх боловсрол -тогтмол зардал	49,023.6	46,350.9	2,672.7	94.5
16	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	65,947.7	63,245.5	2,702.2	95.9
17	Эрүүл мэндийн төв тогтмол зардал	28,166.2	23,006.7	5,159.5	81.7
18	Хоршоо хөгжүүлэх сан үндсэн үйл ажиллагаа	161,130.4	120,470.0	40,660.4	74.8
19	Орон нутгийн хөгжлийн сан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	627,622.2	542,614.4	85,007.8	86.4
	дүн	2,921,903.5	2,233,279.8	688,623.7	76.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 65,048.3 мянган төгрөг, ИТХ 11,814.4 мянган төгрөг, нийт 76,862.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01-2023.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангаж ажилласан 96,0 %	107,315.9	103,012.8
2	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хэрэгжилт 68,2 %	1,689,463.0	1,152,806.2
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх	Шаардлага хангасан 3 зээлдэгчид 120,0 сая төгрөгийн зээл олгосон	161,130.4	120,470.0
4	71802-Ерөнхий боловсролын	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар	Хэрэгжилт 94.1 %	193,234.5	181,773.3
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар	Хэрэгжилт 94.5 %	49,023.6	46,350.9
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар	Хэрэгжилт 95,9 %	65,947.7	63,245.5
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар	Хэрэгжилт 81,7 %	28,166.2	23,006.7
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх	Хэрэгжилт 86,4 %	627,622.2	542,614.4

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баян сумын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн А/01 тоот захирамжаар 1,297,615.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн урсгал санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээ 4, Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэлээс хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 16, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэлээр санхүүжих төсөл арга хэмжээ 2, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 1, малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 4 нийт 27 төсөл арга хэмжээ төлөвлөсөн.

Нээлттэй тендер шалгаруулах 4 хөтөлбөр төсөл арга хэмжээнээс 4 төсөл арга хэмжээг зарласан бөгөөд 1 төсөл арга хэмжээнд оролцогч оролцоогүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ний өдрийн 01/72 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2023 оны батлагдсан нийт зардал 3,163,445.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 47,451.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 35,588.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулах талаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу мэдээллийг бүрэн байршуулахад анхаарч ажиллахыг зөвлөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх зөвлөмжийг хэрэгжилтийг фас системд оруулсан боловч биелэлтийг албан бичгээр ирүүлээгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	458,254.5	1	458,254.5	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>458,254.5</b>	<b>1</b>	<b>458,254.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар нийт авлагын 76,1 хувь буюу 749,471.3 мянган төгрөгийг эзэлж буй орон нутгийн хөгжлийн сангийн болон Засаг даргын тамгын газрын авлага нь хөрөнгө оруулалтын дутуу гүйцэтгэлээс шалтгаалж байгаад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,033,423.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулга хийгдээгүй байна.

1. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бодит байдлын мэдэгдэл, тайлбар тодруулга хийгээгүй. Сангийн яамны Э-тайланд төлөвлөгөө буруу татагдсанаас төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөө 1,033,423.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдээгүй, аймгийн СТСХ-ээс тус залруулгыг ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад залруулахаар болсон тул залруулгыг тооцов.

Аудитаар нийт 18,784.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,691.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 17,093.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.2 Төлбөрийн акт

1.Төрийн албан хаагчийн орон сууцны түрээсийн төлбөрийн тооцоо бодолтыг шалгахад 12 иргэнтэй гэрээ байгуулсан ба 1,691.8 мянган төгрөг дутуу төлөгдсөн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.2-д "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" бол гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

1. Орон нутгийн төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө 1,980,608.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 2,118,081.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөг 106,9 хувиар биелсэн боловч 7 нэр төрлийн орлого 13,0-90,4 хувиар тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татварын батлагдсан төлөвлөгөө 38,947.4 мянган төгрөг, гүйцэтгэлээр 17,093.1 мянган төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 43,9 хувиар буюу 21,854.3 мянган төгрөгөөр тасалсан ба тайлант онд төвлөрсөн 17,093.1 мянган төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 60 дугаар зүйлийн 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 04 дугаар сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	1,033,423.2			1	1,033,423.2	1	1,033,423.2				
ЗДТГ	2	127,492.0	1	88,544.6	1	38,947.4	2	127,492.0				
ОНХС	1	189,321.8			1	189,321.8	1	189,321.8				
Дүн	4	1,350,237.0	1	88,544.6	3	1,261,692.4	4	1,350,237.0				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	0					1	0				
ЗДТГ	1	363,790.7					1	363,790.7				
Дүн	2	363,790.7					2	363,790.7				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ОНХС	1	588,674.8							1	588,674.8		
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Засаг дарга	1	17,093.1							1	17,093.1		
ЗДТГ	3	9,494.7	1	9,494.7					2	0		
ИТХ	2	5,756.7	1	2,525.3					1	3,231.4		
Дүн	6	32,344.5	2	12,020.0					4	20,324.5		
Нийт дүн	7	621,019.3	2	12,020.0					5	608,999.3		